

# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.05.27-05.31

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал улам хүндэрч, АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд буурч хаагдлаа.

S&P 500 индексийн сагсанд багтаж буй эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш дахин хамгийн ихээр унасан бол урт хугацаат хүүний уналттай холбоотойгоор үл хөдлөх хөрөнгийн салбарын компаниудын хувьцаа харьцангуй сайн үзүүлэлттэй байв.

АНУ БНХАУ-ын 200 тэрбум ам.долларын импортын тарифыг нэмж, технологийн гол компани болох "Huawei"-д хориг тавьж, БНХАУ-ын өөр компаниудыг бас онилж байгаа нь худалдааны маргаан даамжрах эрсдэлийг нэмэгдүүлж байгаа юм.

**Европ:** АНУ, БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан хурцдаж, Ерөнхийлөгч Трамп Мексикт нэмэлт тариф тогтоох төлөвлөгөөтэй холбоотойгоор Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд буурчээ.

Европын парламентийн сонгуулийн үр дүнд төвийг сахисан зүүн болон баруун намууд олонхийн суудлаа анх удаа алдаж хэт-барууны популист намууд болон либерал намууд суудлын тоогоо нэмсэн байна. Ингэснээр цаашдаа Европын парламент хэлцэлд хүрэхэд илүү хүндрэлтэй болох хандлагатай байна.

Италийн өрийн хэмжээ хэт өндөр байгаатай холбоотойгоор Ром Бруссель хооронд маргаан үүсэх хандлагатай байна. Италийн өрийн хэмжээ 2020 онд ДНБ-ын 135%-тай тэнцэх хэмжээнд хүрэх хандлагатай байгаа бөгөөд энэ жилийн байдлаар 133.7%-тай байна. Еврозонын улсууд өрийн хэмжээг ДНБ-ын 60%-с дээшгүй хэмжээнд барих шаардлагатай байдаг билээ.

**Япон:** АНУ-БНХАУ хоорондын худалдааны маргаан улам хурцдаж байгаагаас Японы зах зээлийн индексүүд дахин буурч хаагдав.

Японы хэрэглээний үнийн инфляц эрчим хүчний үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор 4-р сард өссөн ч гол инфляцийн үзүүлэлт 0.6 хувиар өссөн нь Японы төв банк (BoJ)-ын зорилтот 2 хувиас хол байна. BoJ нь болзошгүй сөрөг үр дагаврыг харгалзан зорилтот түвшинд хүргэх нэмэлт идэвхжүүлэх арга хэмжээг авахгүй байна.

Японы үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 5-р сард буурсан нь экспортын захиалга хурдацтайгаар буурсантай холбоотой байгаа нь АНУ-БНХАУ хоорондын худалдааны маргааны эдийн засагт учруулах нөлөөг тодотгож байна.

**БНХАУ:** Индексүүд долоо хоногт бага зэрэг өссөн ч сарын үзүүлэлтээр өнгөрсөн оны 10-р сараас хойших хамгийн өндөр уналттай байв. БНХАУ-ын тал Засгийн газрынхаа мэдээллийн агентлагаар дамжуулан АНУ-д газрын ховор элемент нийлүүлэхээ зогсоож магадгүй гэсэн дохио өгөөд байгаа юм. Хэдий тийм боловч тус улс АНУ-тай муудаж буй харилцаагаа улам дордуулахаас зайлсхийсээр байна.

**Эх сурвалж:** Troweprice.com, BloombergTv.mn

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,997.24	0.22% ▲
Dow Jones	АНУ	24,815.04	-3.01% ▼
S&P 500	АНУ	2,752.06	-2.62% ▼
Nasdaq	АНУ	7,453.15	-2.41% ▼
S&P/TSX	Канад	16,037.49	-1.19% ▼
FTSE 100	Их Британи	7,161.71	-1.59% ▼
S&P/ASX 200	Австрали	6,396.90	-0.92% ▼
Nikkei 225	Япон	20,601.19	-2.44% ▼
Hang Seng	Хонг Конг	26,901.09	-1.66% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	110.53
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	99.10
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	98.76
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.13
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.12
DBM' 2023	USD	7.250%	102.11
TDBM' 2020	USD	9.375%	102.97

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.431	0.00 ▲
Libor 3M	2.503	-0.02 ▼
Libor 6M	2.517	-0.03 ▼
Libor 1YR	2.510	-0.11 ▼
US 2YR Bond	1.910	-0.25 ▼
US 3YR Bond	1.862	-0.24 ▼
US 5YR Bond	1.901	-0.22 ▼
US 10YR Bond	2.121	-0.20 ▼

### Валютын ханш /төг/

Валют	2019.05.31	Өөрчлөлт
USD	2,649.35	0.08% ▲
CNY	383.79	0.11% ▲
EUR	2,952.30	-0.32% ▼
RUB	40.55	-1.03% ▼
KRW	2.22	-0.45% ▼
JPY	24.36	0.79% ▲
CAD	1,958.42	-0.45% ▼

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,305.58	1.61% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	14.59	0.20% ▲
Зэс	USD/lb.	264.00	-2.20% ▼
Нүүрс	USD/MT	77.05	-6.15% ▼
WTI газрын тос	USD/bbl.	53.50	-8.75% ▼
Brent газрын тос	USD/bbl.	64.49	-6.11% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.56	-1.54% ▼

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. IV	7.00%
Бодлогын хүү	2019. IV	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. IV	11.02%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. IV	11.83%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. IV	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. IV	17.11%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. IV	10.57%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 41 компанийн 481.8 сая төгрөгийн 2,979,933 ширхэг хувьцаа арилжигдав.

“Хөх ган” /HGN/ компанийн хувьцаа 10.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 88.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Хишиг уул” /HSX/ компанийн хувьцаа 14.80%-аар буурч 426.0 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

5-р сарын 31-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,382.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,997.24 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.22%-аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



\*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	481.8
Зах зээлийн үнэлгээ	2,382,754.2

### Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,997.24	0.22% ▲
MSE I индекс	9,335.72	0.57% ▲
MSE II индекс	7,808.77	0.17% ▲

### Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Даваанбулаг	643,396	97,882,512
Говь	309,459	88,084,094
Монос хүнс	820,414	58,737,347
Таван толгой	7,859	52,041,500
АПУ	81,034	46,171,503

### Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөх ган	88.00	10.00% ▲
Монголын цахилгаан холбоо	450.00	7.14% ▲
Хөвсгөл алтан дуулга	783.78	6.64% ▲
Хай би ойл	50.00	6.38% ▲
Талх чихэр	17,800.00	3.43% ▲

### Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хишиг уул	426.00	-14.80% ▼
Оллоо	68.00	-13.92% ▼
Монгол шилтгээн	350.00	-12.50% ▼
Хөвсгөл хүнс	1,050.00	-10.64% ▼
Фронттиер лэнд групп	170.00	-5.56% ▼

### Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Масдак	192,927,851
Голомт Капитал	120,060,769
Ти Ди Би Капитал	87,231,481
Ард секюритиз	86,876,591
Бумбат-Алтай	76,977,290

### Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	574.99	611,894
Таван толгой	6,600.00	347,590
МИК	13,990.00	289,723
Говь	287.78	224,501
Сүү	199.10	68,490

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.05.03-ны дотор
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Инвекор ББСБ” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээсээ давж хаагдлаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн энэ оны 4 дэх IPO болох “Инвекор ББСБ” ХК нь нийт хувьцааныхаа 15% буюу 1,613,878 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2019 оны 5-р сарын 22-ны өдрөөс өнөөдөр буюу 5-р сарын 30-ны өдрийн 16:00 цаг хүртэл авч дууслаа.

“Инвекор ББСБ” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад нийт 336 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож нийт 2,899,735,069 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх доод дүнгээс 15.9 хувь давсан үзүүлэлт боллоо. Харин стратегийн 14 хөрөнгө оруулагчдаас нийт 16,004,292,500 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь стратегийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх доод дүнгээс 6.1 хувь давсан байна.

“Инвекор ББСБ” ХК нь шинээр гаргасан 1.6 сая ширхэг үнэт цаасыг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын захиалга бүртгэлийн аргыг ашиглан стратегийн хөрөнгө оруулагчдад 1,650-1,750 төгрөгийн хооронд, олон нийтэд 1,550-1,650 төгрөгийн хооронд санал болгосон бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга 100 хувь биелж хуваарилалтыг хийсэн бол олон нийтэд нийлүүлэх нэгж хувьцааны үнийг 1,600 төгрөгөөр тогтоохоор шийдвэрлэлээ. Тогтоосон ханшнаас доогуур захиалга өгсөн хөрөнгө оруулагчдын захиалга биелэх боломжгүй бөгөөд 1,600 төгрөгөөс дээш өгсөн захиалгыг журмын дагуу 90.84 хувиар хувь тэнцүүлэн тооцож хуваарилалт хийнэ.

СЗХ-ноос “Инвекор ББСБ” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх шийдвэрийг гаргасан үед хөрөнгө оруулагчид тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг буцаан авах эрх үүснэ.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж



### “Мон-Ит Булигаар” ХК-ийн хувьцааг худалдан авах тендер санал зарлагдлаа

“Мон-Ит Булигаар” ХК-ийн хяналтын багцыг нэгдмэл сонирхолтой этгээдүүд худалдан авсан тул ҮЦЗЗТ хуулийн 22 дахь заалтын дагуу бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах тендер санал гаргалаа.

Санал болгож буй үнэ: 7,532 төгрөг

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 86.53 хувь

Худалдан авах тоо ширхэг: 53,887 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019.05.27

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019.06.27

Хувьцааны худалдан авах төлбөрийн хугацаа: 2019.06.28

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, АШН-ын хашаа, “Мон-Ит Булигаар” ХК-ийн байр

Дэлгэрэнгүй мэдээллийг 7510 7500 утсаар авна уу.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Мандал даатгал” ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Мандал даатгал” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 90 төгрөг (татварын дараах) тараасныг 2019 оны 5-р сарын 27-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

**Эх сурвалж:** Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв



### “Баялаг налайх” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Компанийн тухай хуулийн 23, 83.1 дүгээр зүйл, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23.1, “Баялаг Налайх” ХК-ийн 12/2018 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/39 тоот тушаалаар “Баялаг Налайх” (MSE:BNB) ХК-ийн гаргасан 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 311,872 ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хасч, арилжааг зогсоолоо.

Тус компанийн үнэт цаасыг биржийн үнэт цаасны бүртгэлээс хассан тухай холбогдох бичиг баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн бөгөөд Хорооны бүртгэлээс хасагдсан тохиолдолд “Баялаг Налайх” хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ болно.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Turquoise Hill Resources”-ийн хувьцааны арилжаа идэвхжиж, “Oversold” бүсэд орлоо

“Оюу Толгой”-ийн хөрөнгө оруулагч “Turquoise Hill Resources”-ийн хувьцааны арилжаа идэвхжиж, “Oversold” буюу “Их арилжигдсан” бүсэд багтсан байна. Пүрэв гарагийн арилжаагаар Торонтогийн Хөрөнгийн биржид хувьцааны ханш нь зургаан хувиар буурч, 1.55 канад доллар болсон бол Нью-Йоркт 6.5 хувиар буурч, 1.14 ам.доллар боллоо.

Лхагва гарагт Эдийн засгийн байнгын хороо “Оюу Толгой”-ийн гэрээний хэрэгжилтийг шалгасан УИХ-ын ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцсэн юм. Үүнээс хойш “Rio Tinto”-ийн хувьцааны ханш Австралийн Хөрөнгийн биржид хоёр өдөр дараалан буурчээ. Баасан гарагийн арилжааг 0.47 хувийн уналттайгаар эхэлж, улмаар нэгж хувьцааны ханш нь 100.58 австрали доллар болоод байна.

“Оюу Толгой” төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар 2039 он гэхэд ойролцоогоор нэг тэрбум ам.долларын өрийн үлдэгдэлтэй хоцорч болзошгүй гэж “Оюу Толгой”-ийн гэрээний хэрэгжилтийг шалгасан УИХ-ын Ажлын хэсгийн ахлагч д.Тэрбишдагва мэдэгдлээ.

Харин “Оюу Толгой” төслийн эерэг талаас дурдвал гадаадын хөрөнгө оруулалт татахад дэмжлэг болсон, улсын төсвийн орлогын долоон хувь, бүртгэлтэй ажиллах хүчний нэг хувийг ажлын байраар хангаж байгааг дурдсан юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### SQM: Литийн эрэлт 2019 онд 17 хувиар өсөх төлөвтэй

Литийн олборлолтоор дэлхийд хоёрдугаарт ордог "SQM" компани литийн эрэлт энэ жил 17 хувиар өснө гэж таамаглаж байна. Улмаар литийн хэрэглээ 2019 онд жилийн үзүүлэлтээр 315 мянган тонн болох төлөвтэй гэж Чилийн олборлогч тус компани дүгнэжээ.

Литийг өргөнөөр ашигладаг цахилгаан тээврийн хэрэгсэл үйлдвэрлэгч "Tesla" зэрэг компаниудын эрэлт 2021 он хүртэл жилд 20 хувиар нэмэгдэж байгаа юм байна. Хэдий тийм боловч үнэ нь буурч байгаа ажээ. I улиралд литийн ханш найман хувиар буурсан бол ойрын саруудад 25 хувиар буурах төлөвтэй гэж таамаглаж байгаа аж. Эрэлт их байгааг дагаад энэ жил литийн олборлолт эрчимжиж, зах зээлд илүүдэл үүссэнээр ийнхүү ханшид нөлөөлнө гэж "SQM" дүгнэжээ.

"SQM"-ийн хувьд Чилийн хойд хэсэг дэх олборлолтоо өргөжүүлж, жилийн гарцаа 2021 он гэхэд 120 мянган тонн болгон нэмэхээр төлөвлөж байна. Мөн Австралид хоёр дахь литийн төслөө эхлэхээр бэлтгэж байна. "SQM"-ийн санхүүгийн тайланд дурдсанаар I улиралд нэг тонн литийн дундаж ханш 14 600 ам.доллар байгаа бол оны хоёрдугаар хагаст худалдан авагчидтай хийж байгаа хэлцлээр бол 11-12 мянган ам.доллар болж магадгүй юм байна.

Энэхүү мэдээлэлтэй зэрэгцээд АНУ-д бүртгэлтэй "SQM"-ийн хувьцааны ханш пүрэв гарагт 8.2 хувиар унажээ.

Лити нь цахилгаан автомашин, гар утас зэрэгт өргөнөөр ашиглагддаг. Хамгийн их нөөцтэй улс нь Чили юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Шатахууны үнийг үндэслэлгүйгээр 97-161 төгрөгөөр нэмжээ

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар /ШӨХТГ/-аас хийсэн шалгалтаар, шатахууны жижиглэн худалдаа эрхлэгч ААН-ийн шатахуун, түлш нь энэ сард 97-161 төгрөгөөр үндэслэлгүй нэмэгдсэн байна. Энэ талаар тус газраас өнөөдөр мэдээлсэн юм.

Шатахуун, түлшний жижиглэн борлуулах үнийг Шатахууны худалдаа эрхлэгч ААН-үүд он гарсаар удаа дараалан нэмсэн. Энэхүү үнийн нэмэгдэл нь бодитой эсэх, Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нийцэж байгааг тогтоохоор дээрх шалгалтыг 17 ААН-д явуулжээ.

ШӨХТГ-ын дарга Б.Лхагва хэлэхдээ, "Шалгалтаас харахад, ААН-үүд АИ-92 шатахуунаа литр тутамд 30-100 төгрөгөөр нэмсэн байна. Түлш нь литр тутамдаа 270-289 төгрөгийн ашигтай байсан ч үнийг нь дахин нэмжээ. Шалгалтад хамарсан 17 ААН-ийн ирүүлсэн мэдээллээс харахад, гадаад хилийн үнэ нэмэгдсэн ч жижиглэн борлуулах үнийг нэмэх нөхцөл үүсээгүй нь тогтоогдсон. ШӨХТГ-аас шатахууны үнийг шууд хянах эрх зүйн зохицуулалт байдаггүй. Тиймээс үүнд арга хэмжээ авах санал дүгнэлтээ Засгийн газар болон АМГТГ, холбогдох яам, агентлагт хүргүүлсэн" гэв.

**Эх сурвалж:** Montsame.mn



### Fitch Solutions: Коксжих нүүрсний ханш 2019 оны үлдсэн хугацаанд өсөлтөө хадгална

Коксжих нүүрсний ханш 2019 онд харьцангуй чанга хэвээр буюу тонн нь 195 ам.долларт хэлбэлзэнэ гэж "Fitch Solutions" таамаглаж байна. БНХАУ-АНУ-ын худалдааны маргаанаас үүсэж байгаа эрсдэлээс хамгаалахын тулд Бээжингийн эрх баригчид эдийн засгийг дэмжих хөтөлбөрөө идэвхжүүлнэ гэж үзэж байна.

Үүний дүнд БНХАУ-ын гангийн салбарт коксжих нүүрсний эрэлт нэмэгдэнэ гэж тооцоолж байгаа юм. Нийлүүлэлт талаасаа Австралийн коксжих нүүрсний олборлолт таамагт хүрэхгүй байх төлөвтэй байгаа нь зах зээлийг хумьж, улмаар ойрын хэдэн улиралдаа ханш харьцангуй чанга байна гэж төсөөлж байна. Харин урт хугацаандаа БНХАУ-ын гангийн салбарын өсөлт саарч Австралид олборлосон коксжих нүүрсний эрэлт буурна гэж харж байна. Энэтхэг улс Австралийн коксжих нүүрсний импорттоор дэлхийд тэргүүлдэг бөгөөд тус улсын I улирлын импорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7 хувиар буурсан байгаа юм.

Австралиас импортлон авч байгаа коксжих нүүрсний хэмжээгээр БНХАУ хоёрдугаарт орж байгаа аж. Тус улсын импорт I улиралд өмнөх оны мөн үеэс 35 хувиар өсөөд байна. 2020 оноос хойш Австралид олборлосон коксжих нүүрсний ханш олон жил үргэлжлэх уналтын бүсэд шилжинэ гэж "Fitch Solutions" таамаглаж байна.

БНХАУ-ын тухайд коксжих нүүрсний олборлолт нь 2028 он хүртэл өсөх чиглэлд байж, жилийн 551 сая тонн хүрэх төлөвтэй байгаа ажээ. ОХУ-ын коксжих нүүрсний олборлолт өссөөр 2026 он гэхэд Индонезийг давж, дэлхийд гуравдугаарт бичигдэнэ гэж харж байна. Коксжих нүүрсний зах зээлд цаашдаа БНХАУ, Австрали, Индонез улсын олборлолтын хувь буурч оронд нь ОХУ, Энэтхэг, Монголынх нэмэгдэх төлөвтэй байгааг "Fitch Solutions" тайландаа онцолжээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### ХААБ: Өнгөрсөн долоо хоногийн арилжааны үнийн дүнгийн 98 орчим хувийг боловсруулаагүй ноолуурын арилжаа бүрдүүлсэн

Хөдөө аж ахуйн бирж 5-р сарын 20-24-ны хооронд 21.5 тэрбум төгрөгийн түүхий эд арилжжээ. Энэ нь V сарын хоёр дахь долоо хоногтой харьцуулахад 2.3 дахин бага дүн болсон байна. Арилжааны үнийн дүнгийн 98 орчим хувийг боловсруулаагүй бараан болон цайвар ноолуурын арилжаа бүрдүүлжээ.

Боловсруулаагүй бараан ноолуурын үнэ сүүлийн нэг жилд 21 хувиар өсөж кг тутам нь хамгийн сүүлийн байдлаар 119 орчим мянган төгрөгт хүрээд байна. Мөн хамгийн идэвхтэй арилжаалагддаг боловсруулаагүй цайвар ноолуурын үнэ өнгөрсөн нэг жилд 16 орчим хувиар өсөж сүүлийн арилжаагаар 120 орчим мянган төгрөгт хүрчээ. Үүнээс гадна өнгөрсөн долоо хоногт ХААБ хонь, ямааны завод ноос, адууны боловсруулаагүй шир арилжсан. Гэхдээ эдгээр түүхий эд арилжааны үнийн дүнгийн гурав хүрэхгүй бага хувийг эзэлж байгаа юм.

Засгийн газрын тогтоолоор "Эмээлт" захад хуримтлагдаад байгаа боловсруулаагүй адууны ширний стандарт хангаагүй хэсгийг хөдөө аж ахуйн биржээр бүртгэлжүүлэн дэл сүүлгүйгээр арилжаалахаар болсон. Энэ ажлын хүрээнд ХААБ боловсруулаагүй адууны ширийг бүртгэлжүүлж, "Их зам транс" ХХК-ийн компанийн агуулахад итгэмжлэл олгожээ. Мөн байнгын гишүүн хөдөө аж ахуйн брокерын компаниудаар зуучлуулан биржийн арилжааг зохион байгуулж байгаа юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## БУСАД МЭДЭЭ

### Ирэх онд инфляцийн түвшин 8 хувиас ихгүй байна

УИХ-ын чуулганы өнөөдрийн хуралдаанаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай тогтоол батлав.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд 20 зорилтын хүрээнд 118 ажил өрнүүлэхээр тусгажээ. Эдгээрт 10 их наяд 216.3 тэрбум төгрөг шаардлагатай байгаагаас улсын төсвийн хөрөнгөөр 1 их наяд 325.5 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 2 их наяд 111.9 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 6 их наяд 174.2 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 604.7 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үндсэн чиглэлийг амжилттай хэрэгжүүлснээр эдийн засгийн бодит өсөлт 6 хувь байхаар тооцжээ. Мөн инфляцийн түвшин 8 хувиас ихгүй, төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээ 5.1 хувиас ихгүй, ажилгүйдлийн түвшин 6.5 хувиас бага байх аж.

**Эх сурвалж:** Montsame.mn

### Гадаадын хөрөнгө оруулалт 717 сая ам.доллаароор нэмэгджээ

Монголбанкнаас өнөөдөр оны эхний улирлын банк, санхүү, мөнгөний талаарх статистик мэдээллийг танилцуулж, сар бүрийн цаг үеийн ээлжит мэдээллээ хийлээ.

Мөнгөний нийлүүлэлт: (М2 мөнгө) Өнгөрсөн дөрөвдүгээр сарын байдлаар 19.9 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 22.6 хувь, өмнөх сараас 1.1 хувь тус тус нэмэгдэж, жилийн өсөлт 210 тэрбум төгрөг болоод байна.

Мөнгөний нийлүүлэлтийн 55.1 хувийг төгрөгийн хадгаламж, 15.2 хувийг төгрөгийн харилцах, 14.4 хувийг валютын хадгаламж, 12 хувийг валютын харилцах хэлбэрээр хадгаламжид байршиж буй эх үүсвэр эзэлж, үлдсэн 3.2 хувийг хадгаламжаас гадуурх байгууллагуудын мөнгө бүрдүүлж байна.

Мөнгөний нийлүүлэлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг нийт хадгаламжийн хэмжээ 13.8 их наяд төгрөг хүрсний 80.4 хувийг иргэдийн хадгаламж, 19.6 хувийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна. Иргэдийн нийт хадгаламжийн 19.4, байгууллагуудын хадгаламжийн 25.9 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байгааг Монголбанкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир мэдээллээ.

Зээл: Банкуудын зээлийн үлдэгдэл өнгөрсөн 4-р сарын байдлаар 17.5 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь өнгөрсөн оноос 22 хувиар, өмнөх сараас 1.2 хувиар өссөн дүн юм. Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 28 хувиар өсөж, 9.1 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 15 хувиар өсөж, 8.2 их наяд төгрөгт тус тус хүрээд байна. Зээлийн үлдэгдлийг салбаар авч үзвэл цалин, тэтгэврийн зээл нийт зээлийн 24 хувийг, худалдааны зээл 15 хувийг, үл хөдлөх хөрөнгийн зээл 11, барилгынх 9 хувийг тус тус эзэлж байна.

**Эх сурвалж:** Montsame.mn



### Монгол Улс ЕХ-ны зах зээлд 74 сая еврогийн бүтээгдэхүүн экспортолжээ

Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ)-ын удирдлагууд Европын холбооны гишүүн улсуудаас манай улсад суугаа Элчин сайдуудтай өнөөдөр уулзаж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийн талаар санал солилцлоо.

Манай улс 2005 онд Европын холбооны шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдаж 7200 төрлийн бараа, бүтээгдэхүүн татваргүй экспортолж боломжтой болсон. Гэвч боломжоо бүрэн ашиглаж чадахгүй байгаа аж. Тодруулбал, 2018 онд Европын холбооны зах зээлд ердөө 74 сая еврогийн экспорт хийсний дийлэнхийг самнасан ноолуур, сүлжмэл бүтээгдэхүүн, эсгий, өлөн гэдэс, хивс, монгол гэр, гэрийн тавилга, хагас боловсруулсан арьс шир зэрэг цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн эзэлжээ. Харин Европын холбооноос 313 сая еврогийн бүтээгдэхүүн импортолсны 88 хувийг тоног, төхөөрөмж эзэлсэн байна. Тиймээс экспортын бүтээгдэхүүний төрлийг олшруулах, Европын холбооны чанарын стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэхэд төрийн болон ТББ-ууд хамтран ажиллах шаардлагатай байгааг МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин уулзалтын үеэр онцоллоо.

Элчин сайдууд ч манай улсын экспортын бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, экспортын судалгаа хийх, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн төлөө идэвхтэй ажиллахаа илэрхийлж байв.

Европын холбооноос Монгол Улсын эдийн засгийг уул уурхайн салбараас хэт хараат байдлаас салгаж, төрөлжүүлэхэд нь туслах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, Монголын эдийн засаг, худалдааны бүтэц хэлбэрийг төрөлжүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй юм. Тодруулбал, Европын холбооны EU-TRAM төслийн хүрээнд органик гоо сайхны бүтээгдэхүүн, сарлаг болон ботгоны ноос, чацарганы тос болон арьс ширний үйлдвэрийг хөгжүүлж буй юм. Төслийн хүрээнд төрөл тус бүрт нэмүү өртөг шингээхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн, кластер үүсгэн ажиллаж байна.

**Эх сурвалж:** Montsame.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.